

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
3.БУЯНТ
2024 оны 09 дүгээр сарын 24

ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

2024 оны 9 дүгээр сарын 24

Улаанбаатар хот

Зорилго: Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг төрийн албан хаагчдад таниулах, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон авлигын эсрэг үйл ажиллагааг Хан-Уул дүүргийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд сурталчлах.

Зохион байгуулагч: Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
Хамтран зохион байгуулагч: Авлигатай тэмцэх газар
Хамрах хүрээ: Засаг даргын Тамгын газар, 25 хорооны төрийн албан хаагчид болон Хан-Уул дүүргийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд.
Хугацаа: 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр.
Хэрэгжүүлэх арга хэмжээ;

№	Арга хэмжээний нэр	Оролцогч	Хариуцах албан хаагч	Хугацаа
1	Батлагдсан удирдамж болон зурагт хуудсыг хороодод хүргүүлэх, тайлагнах	-	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хүний нөөц, хөрөнгө, орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн Б.Саранцацрал	2024.09.24-2024.09.27
2	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн сурталчилгаа бүхий зурагт хуудас тараах	Засаг даргын Тамгын газар болон 25 хорооны төрийн албан хаагчдаас төрийн үйлчилгээ	Төрийн албан хаагчид	2024.09.27-ны өдрийн 08:00-17:00 цагийн хооронд
3	Засаг даргын Тамгын газар болон 25 хорооны төрийн албан хаагчдаас төрийн үйлчилгээ авахаар ирсэн Хан-Уул дүүргийн иргэдийн гар утсанд Товш аппликэйшн суулгаж өгөх	Засаг даргын Тамгын газар болон 25 хорооны төрийн албан хаагчдаас төрийн үйлчилгээ авахаар ирсэн Хан-Уул дүүргийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллага		

№	Арга хэмжээний нэр	Хамрах хүрээ	Хариуцах албан хаагч	Хугацаа
4	Хан-Уул дүүрэгт худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн, нэгж байгууллага болон иргэдэд худалдаа, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээлэл бүхий видео шторкийг Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчилэх төв байрны Нэг цэгийн үйлчилгээний төв болон 25 хорооны дэлгэцээр явуулж олон нийтэд сурталчлах	Засаг даргын Тамгын газар болон 25 хорооны төрийн албан хаагчдаас төрийн үйлчилгээ авахаар ирсэн Хан-Уул дүүргийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллага	Төрийн албан хаагчид	2024.09.27-ны өдрийн 08:00-17:00 цагийн хооронд
5	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн видео шторкийг Хан-Уул дүүргийн Иргэдэд үйлчилэх төв байрны Нэг цэгийн үйлчилгээний төв болон 25 хорооны дэлгэцээр явуулж олон нийтэд сурталчлах			

Хүрэх үр дүн:


- ✓ Төрийн албан хаагчдын оролцоотойгоор Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчилж иргэд мэдээллээр хангагдана;
- ✓ Худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн, нэгж байгууллага болон иргэдэд худалдаа, үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээллийг иргэдэд хүргэнэ.

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Ч.АРИУНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНИЙ НӨӨЦ, ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.САРАНЦАЦРАЛ